

НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР “НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУД” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Нийслэлийн залуучууд” дэд хөтөлбөр нь 6 бүлгээс бүрдэнэ.

Нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл

1.1 Үндэслэл

Монгол Улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.1, “Нийслэлийн залуучуудын талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ”, гэсэн зорилтуудыг тус тус үндэслэл болгов.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ:

Залуучууд бол улс орны хөгжлийг хөдөлгөгч томоохон нөөц, ихийг бүтээх суурь хүч нь байдаг. Монгол Улсад 15-34 насны 1'085'000 гаруй залуучууд байгаа нь хүн амын 34.5 хувийг эзэлж байна. Мөн нийслэлийн нийт хүн ам болох 1'345'500 иргэдийн 476'624 буюу 35.4 хувь нь 15-34 насны залуучууд эзэлж байгаагийн дотор 231'086 буюу 48.8 хувь нь эрэгтэй, 245'538 буюу 51.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Хоёрдугаар бүлэг. Хөтөлбөрийн зорилго, зорилт;

Зорилго.

Залуучуудад иргэний ёс суртахууныг төлөвшүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийн орчин нөхцөлийг сайжруулж, нийслэлийн хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод залуучуудын санаачилга оролцоог дэмжих тогтолцоо бүрдэж, эрүүл чийрэг оюунлаг, бүтээлч, залуус манлайлсан хот болгоход оршино.

2.1 Зорилтууд.

- 2.1.1 Залуучуудын бодит оролцоог нэмэгдүүлж, эерэг хандлагатай, бүтээлч иргэн болгон хөгжүүлнэ;
- 2.1.2 Залуучуудыг эрүүл амьдралын хэв маягт сургаж, гэр бүлийн боловсрол олгож, амьдрах ухааны мэдлэг, чадварыг эзэмшүүлнэ;
- 2.1.3 Залуучуудад нарийн мэргэжил эзэмших ач холбогдлыг ойлгуулах сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулна;
- 2.1.4 Залуучуудын амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх хөгжлийн орчин, үйлчилгээг шинээр нэвтрүүлнэ;

Гуравдугаар бүлэг. Хэрэгжүүлэх үе шат, хугацаа, үйл ажиллагаа

Нийслэлийн 15-34 насны залуучуудыг хамарна. /ЕБС, Их, дээд сургууль, МСҮТ, бусад залуучууд/

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

Залуучуудад хотын иргэний талаарх ойлголтыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулж, урлагаар дамжуулан залуучуудын дунд эерэг дүр төрх бий болгохыг дэмжих, залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, түүх, соёл, хөгжлийг судлах "Залуучууд судлал" эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлийг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах, залуучуудын дунд нийгэмд дагаж мөрдөх амьдралын зөв дадал, чадвар олгох аяныг өрнүүлэхээр тусгав.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

Өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн анхан шатны мэдлэг болон гэр бүл, нөхөн үржихүйн боловсрол олгох, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, залуучуудад амьдрах ухааны мэдлэг чадвар олгох сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахаар тусгав.

Гуравдугаар зорилтын хүрээнд:

Залуучуудын мэргэжил сонгох хандлагыг сайжруулах арга хэмжээг мэргэжлийн байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах, гадаад, болон дотоодод сурч боловсрон, нарийн мэргэжил эзэмшсэн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах, зорилтот бүлгийн залуучуудад хөдөлмөр эрхлэх таатай боломжоор хангахад дэмжлэг үзүүлэх аян өрнүүлэх, мэргэжлээрээ үр бүтээлтэй, амжилттай ажиллаж байгаа болон гоц авьяастай оюуны өндөр чадамжтай өсвөр үе, залуучуудын бүтээл туурвил, бодит санал санаачилгыг дэмжин алдаршуулах үйл ажиллагаануудыг зохион байгуулахаар тусгав.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дэргэд болон дүүргүүдэд “Залуучуудын хөгжлийг дэмжих төв”-ийг нээн ажиллуулах, залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг талуудтай хамтран зохион байгуулж, хөгжлийн орчин үйлчилгээг шинээр бий болгохоор тусгав.

Дөрөвдүгээр бүлэг. Үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

- Нийслэлийн нийт залуучуудын 60 хувь нь нийгэмд дагаж мөрдөх 10 зөв дадал, эерэг хандлагын талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.
- Нийслэлийн нийт залуучуудын 40 хувь нь гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, эрүүл мэндийн зөв дадал хэвшлийн талаар ойлголт, мэдээлэлтэй болж, эрсдэлээс хамгаалах чадвар эзэмшсэн байна.
- Залуучууд нарийн мэргэжил эзэмшихийн давуу талыг ойлгож, 3000 залууг мэдээллийн технологийн чиглэлээр сургасан байна.
- Залуучуудын хөгжлийг дэмжих төв байгуулан залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийгэм соёлын олон талт арга хэмжээнд оролцох нөхцөл боломж бүрдсэн байна.

Тавдугаар бүлэг. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1 Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлж, үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

5.1.1 Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт;

5.1.2 Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.3 Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.4 Бусад эх үүсвэр;

Зургаадугаар бүлэг. Хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

6.1 Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, хэлэлцүүлнэ.

6.2 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хэрэгжилтийн явцад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан хоёр жил тутам Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

6.3 Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар хяналт-шинжилгээ, үнэлгээний санал зөвлөмжийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР